



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 85

Номгон

Автомашиныг хяналтын дагуу хөдөлгөөнд  
оролцуулах зөвшөөрлийн хураамжийн  
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцаны мэлмий гийсний 380 жилийн ой, Даншиг наадмыг тохиолдуулан 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс 28-ны өдрүүдэд автомашиныг хяналтын дагуу хөдөлгөөнд оролцуулах зөвшөөрлийн хураамжийн хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2. Хураамжийн орлогыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж баяр наадмын төлөвлөгдсөн арга хэмжээнд зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ц.Дашцэрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА




Ц.ОТГОНБАЯР

1190135

D:/2018/Alban bichig/th togtool-2019

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын  
23-ны өдрийн 85 дугаар тогтоолын хавсралт



АВТОМАШИНЫГ ХЯНАЛТЫН ДАГУУ ХӨДӨЛГӨӨНД  
ОРОЛЦУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Зөвшөөрлийн ангилал	Хураамжийн хэмжээ/мян/төг/
1	“А” зөвшөөрөл	-
2	“Б” зөвшөөрөл	5000
3	“К” зөвшөөрөл	-
4	“Ү” зөвшөөрөл	20000

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_